

## ХҮМҮҮЖЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН /2019 оны 9-р сар/

Энэ хичээлийн жилийн сургалтыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулж буй хүмүүжил төлөвшлийн ажлууд нь “Хүүхдийн хамгаалалд хүн бүрийн оролцоо” уриан доор зохион явуулж байгаагаараа онцлог юм.

1. Тус сургуулийн суралцагчдын эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхдээ бид холбогдох, эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж ирсэн. Суралцагчдын эрүүл мэндийн үйлчилгээг холбогдох байгууллага хувь хүнтэй хамтран зохион байгуулж эхлээд байна. Тухайлбал 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн Б.Одцэцэг, эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан Б.Энхчимэг нар тус сургуулийн суралцагчдад “Архи, тамхи,” “Вирусын халдварт өвчин”, “Бэлгийн замын халдвараас сэргийлэх нь” сэдэвт лекц сургалтыг зохион явуулж хамтран ажилла. Бидний өдөр тутамд ч тохиолдож болох эрүүл мэндтэй холбоотой эрсдэл аюул ойрхон байгааг жишээ татаж тайлбарлаж өглөө. Мөн суралцагчдын сонирхсон асуултад хариулт өглөө.




*СБД-ийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн Б.Энхчимэг, Б.Одцэцэг*



*10, 11-р ангийн 170 гаруй суралцагчид оролцлоо*

2. Мөн тус сургуулийн 15 настангуудын судалгаа гаргаж 10, 11-р ангийн 70 гаруй суралцагчдыг графикт вакцинд хамруулж, мөн элэгний В, С вирусг илрүүлэх шинжилгээнд хамрууллаа. В вирусээр халдвар тээгч суралцагч илрээгүй бөгөөд энэ төрлийн вирусээс хамгаалах вакцинд шинжилгээ өгснөөс хойш 30 хоногийн хугацаанд хамрагдахыг зөвлөлөө.




*СБД-ийн 7-р хорооны Энхсүндэр өрхийн эмнэлгийн эмч нар вакцин хийж буй нь*



*Элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ хийж буй нь*

3. АНУ-ын Мичиганы их сургуулийн оюутан Б.Саруул тус сургуулийн 10, 11-р ангийн суралцагчдад АНУ-д хэрхэн суралцах талаар зөвлөгөө мэдээллийг өөрийн туршлагаасаа хуваалцан, арга барил, зөвлөмжийг өглөө.



*АНУ-ын Мичиганы их сургуулийн оюутан Б.Саруул туршлагаа ярьж буй нь*

4. Тус сургуульд мэргэжлийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш нарын зөвлөн туслах үйлчилгээ тасралтгүй явагдаж байдаг хэдий ч хүүхдийн сэтгэл зүйн нийтлэг болон ганцаарчилсан асуудалд мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөгөө авах хэрэгцээ шаардлага зайлшгүй гарч байдаг.

Иймд бид сэтгэл судлаачаар мэргэшсэн, мэргэжлийн сэтгэл зүйч АШУ-ны доктор П.Мишээлийг 2019 оны 10 дугаар сарын 01 өдөр урьж 10, 11 дүгээр ангийн суралцагчдад сэтгэл зүйн зөвлөгөө, лекц сургалтыг авлаа. Сэтгэл зүйч Д-р. П.Мишээл нь ХБНГУ, Япон, ОХУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад сэтгэл зүйн чиглэлээр судалгаа хийж суралцсан мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн сэтгэл судлаач гэдгээрээ онцлог байлаа.

Тэрээр өсвөр насны (14-21) хүүхэд залуусын сэтгэл зүйн асуудлын нийтлэг шинж нь тэдний байгалиас заяагдсан төрмөл, мөн бие физиологийн өөрчлөлт, онцлогт тулгуурлан ерөнхийдөө төстэй буюу нийтлэг байх хэв шинжийг тодорхой тайлбарлаж өглөө.

Түүнчлэн сэтгэл зүйн асуудлын гол объект нь хувь хүний хүмүүжил, төлөвшилтэй салшгүй холбоотой байдаг байна. Тухайлбал *“Хүн чанар бол хүн болгонд заяадаггүй ховор бэлэг, Хүмүүжил бол хэн дуртай нь эзэмшээд байдаггүй том боловсрол”* гэдэг үг бий. Хүмүүжилтэй хүн л хүнийг хайрладаг бас хүндэлж чаддаг гэнэ. Ялангуяа аав, ээж, гэр бүл, багш нар, ойр дотны хүмүүс болон бусдыг зүгээр л хайрлаж сур, байгаагаар нь хүлээж авахыг эрхэмлэ! гэж зөвлөв. Аливаа асуудалд ухаалгаар хандаж хэн нэгний тусламж зөвлөгөөг заавал авч байхыг зөвлөлөө. Хувь хүний төлөвшил гэдэг бол нийгэмд эзлэх байр суурь юм. Аливаа асуудалд чинь сэтгэлээсээ хандаж байх ёстой. Өөрөөр хэлбэл өөрийгөө зас, дараа нь гэрээ зас, гэрээ зассан хүн төрөө засна гэдэг үгтэй утга нэг санагдлаа.

Энэ насныхны сэтгэл зүйн онцлогийг ойлгуулахаар харилцан ярилцаж 120 гаруй минут буюу бүтэн 2 цаг үргэлжилсэн энэхүү зөвлөгөө нь манай суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалт боллоо. Суралцагчид өөрсдийн сонирхсон асуултаа амаар болон бичгээр дамжуулан хариултаа авлаа. Мөн ганцаарчилсан үйлчилгээ авах шаардлагатай суралцагчтай тусгайлан уулзуулж зөвлөгөө авлаа.

Тус сургуулийн нийгмийн ажилтан Д.Оюунгэрэл, 11е ангийн суралцагч А.Анхил нар нэлээд олон сарын өмнө сэтгэл зүйч П.Мишээлд санал тавьж ирүүлэхээр төлөвлөгдсөн энэхүү ажил амжилттай сайхан зохион байгуулагдлаа. Цаашид хүүхдийн сэтгэл зүйн талаар тулгамдсан асуудалд хамтарч ажиллах саналыг бид тавьсан юм.



*Сэтгэл судлаач Д-р.П.Мишээл, нийгмийн ажилтан Д.Оюунгэрэл, оролцогч суралцагч нарын хамт*



Хянасан: Захирал П.Түвшинтөр

Тайлан бичсэн: Нийгмийн ажилтан Д.Оюунгэрэл